



UVS.KHURAL.MN ДЭД ЦАХИМ ХУУДАС 1 САЯ ТӨГРӨГӨӨГ ШАГНУУЛЛАА.

2015 оны 10-р сард зарлагдаж 12-р сарын 1-нийг хүртэл үргэлжилсэн Khural.mn дэд цахим хуудсыг хөгжүүлэх уралдааны дүн гарч Увс аймгийн ИТХ-ын албан ёсны цахим хуудас uvs.khural.mn дэд цахим хуудас нийтэлсэн мэдээ мэдээллийн тоо, чанар, шалгуур үзүүлэлтийг хангасан байдлаараа уралдааны болзолыг ханган 1 сая төгрөгөөг шагнууллаа.



uvs.khural.mn дэд цахим хуудас нь 2014 оны ажлаараа мөн улсад шалгаран 1 сая төгрөгөөр шагнуулж байсан юмаа.

ШАТАР СОНИРХОГЧДЫН АЙМГИЙН АВАРГУУД ТОДОРЛОО.

Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулах Монгол Улсын Ардчилсан шинэ үндсэн хуулийн өдөрт зориулсан 2016 оны шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах дөрөв дэх удаагийн тэмцээний хоёрын даваа болох ардчилал, хүний эрхийн өдөрт зориулсан аймгийн аварга шалгаруулах тэмцээн өнгөрсөн амралтын өдрүүдэд цогцолбор нэгдүгээр сургуулийн урлагийн зааланд амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа.

Эрэгтэйчүүдээс Д.Лувсанням / Улаангом сумын иргэн/, О.Эрдэнэтөгтох / Баруунтуруун сумын иргэн/, Д.Цэвээн / Улаангом сумын өндөр настан/ Эмэгтэйчүүдээс Ж.Алтанцэцэг /Улаангом сум/, М.Долгормаа /Тэс сум/, Ж.Ундармаа / Улаангом сум/ нар шалгарлаа.



Эрэгтэй төрөлд шалгарсан Д.Лувсанням, О.Эрдэнэтөгтох, эмэгтэй төрөлд шалгарсан Ж.Алтанцэцэг нар 2016 оны 01 сарын 09-10 хооронд Төрийн ордонд зохион байгуулагдах шигшээ уралдаанд оролцох эрхээр бичиг гардан авлаа.

АЙМГИЙН ИТХ-ЫН ҮЕ ҮЕИЙН ДАРГА НАР УУЛЗЛАА

Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд өмнөх бүрэн эрхийн хугацаанд ажиллаж байсан аймгийн ИТХ-ын дарга Ё.Басан, Д.Батсайхан нарыг хүлээн авч уулзлаа.

Ё.Басан дарга нь 1996-2000, 2000-2004 онд, Д.Батсайхан дарга нь 2004-2008, 2008-2012 онд тус бүр 2 бүрэн эрхийн хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан юм.



Уулзалтын үеэр аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэл, ИТХ болон ЗДТГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж санал солилцон шинэ жилийн мэндчилгээ дэвшүүллээ.



ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ:

2015 оны 12 сарын 31-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан хуралдаж дараах хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

- 1. Монгол Улсын сайн малчин, Тэргүүний тариаланч тодорхойлох тухай.
2. Орон нутгийн өмчийн асуудал.



УВС АЙМАГ "ГУДАМЖ" ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.



Шинэчлэлийн Засгийн газар 1.5 сая ам долларын "Чингис" бондыг босгож, 2013 оноос "Гудамж" төслийг Улаанбаатар хот болон Архангай, Хэнтий, Увс аймгуудад хэрэгжүүлж эхэлсэн билээ. Гудамж төслийн ажлыг хүлээн авах ёслолын арга хэмжээнд УИХ-ын дарга З.Энхболд, Шинэчлэлийн ЗГ-ын тэргүүн асан Н.Алтанхуяг нар оролцож үг хэллээ.

З.ЭНХБОЛД: "Гудамж төсөл"-ийг Улсын нийслэлд ч, аймгийн

хэрэгжүүлэхэд амар хялбар төвүүдэд ч хот төлөвлөлтийн бодлого алдагдаж, замбараагүй газар олгосоны уршгаар зам тавих газрыг чөлөөлөх ажил багагүй бэрхшээлтэй тулгарсан. Батболд захиралтай "Гудамж төсөл"-ийн баг, аймаг, хотын удирдлага, иргэдийн хамтын ойлголцол, хүчин чармайлтын үр дүнд Улаанбаатар болон дээрхи гурван аймагт энэ төсөл амжилттай хэрэгжиж байгааг онцлон тэмдэглэж байна.



Энэ ажлыг Увс аймагт сайн зохион байгуулсан аймгийн удирдлага, гүйцэтгэгч "Шинжан Шин фа" компани, хамтран ажилласан Увс аймгийн "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨК, "Цахилгаан холбоо", "Ундарга Увс", "Дэвшил Увс", компани болон замын ажилд оролцсон нутгийн иргэд, төрийн бодлогыг дэмжиж газраа чөлөөлж өгсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд, нийт Увсчууддаа талархал илэрхийлье.



УВС АЙМГИЙН ЦАГААТГАЛЫН КОМИСС ШИЛДГЭЭР ШАЛГАРЛАА

Аймгийн ЦАУЗБСалбар комиссоос өнгөрсөн 25 жилийн хугацаанд хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээх, дурсгалыг нь мөнхжүүлэх, хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, үр хүүхэд төрөл төрөгсдөд нөхөх олговор олгох, тэднийг нийгмийн халамжийн болон мөнгөн тусламж, дэмжлэгүүдэд өргөнөөр хамруулах, санал хүсэлт өргөдөл гомдлыг нь шуурхай барагдуулах, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, нөхөх олговор болон бусад лавлагаа, магадлагаа, гэрчилгээ авахад нь хууль эрх зүй, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, лавлагаа мэдээллээр

хангах, материалын бүрдүүлэлтэнд нь хяналт хийж зөвлөгөө өгч уламжлан шийдвэрлүүлэх болон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль, түүнд орсон нэмэлтүүд, цагаатгалын асуудалтай холбогдох бусад шийдвэр, журмуудыг сурталчлах, тайлбарлан таниулах, энэ асуудлаар хурал цуглаан, семинар сургалт зохион байгуулах, ой түүх дурсгалыг тэмдэглэн өнгөрүүлэх, түүнчлэн хэлмэгдүүлэлтийн түүхтэй холбогдох судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлыг хийж ирсэн юм.

Увс аймгийн Цагаатгалын комиссоос хэрэгжүүлсэн дээрх ажлуудыг үнэлэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын 25 жилийн ойн арга хэмжээний үеэр Увс аймгийн салбар комиссыг "Шилдэг салбар комисс"-оор шалгарууллаа.

УЛААНГОМ СУМ:

Улаангом сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар орон нутгийн өмч бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт түүнд тавих хяналтыг сайжруулах талаарх ажлын хэсэг байгуулагдан сумын ИТХ, ЗДТГ, багийн төв, соёлын төв, Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газар зэрэг



байгууллагуудаар орж санал дүгнэлтээ гаргалаа. Мөн сургуулиудын үйл ажиллагаа, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, 3 талт гэрээний үр дүн, дотуур байр бүхий сургуулиудын орчин нөхцөл, суралцагчдын сэтгэл ханамж, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа, үдийн цай хөтөлбөрт сургууль болон эцэг эхчүүдийн зүгээс тавивж буй хяналт зэргийг

судлан үзэж сургуулиудаас гаргаж буй санал хүсэлтийг сонсож цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгч ажиллалаа.



САГИЛ СУМ:

ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаар 21 төлөөлөгч оролцохоос 19 төлөөлөгч оролцож дараахь асуудлуудыг хэлэлцээд шийдвэрлэв.

1. ИТХ-ын 2015 оны ажлын дүн, цаашдын зорилтын
2. Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон 2015 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын биелэлт, цаашид авах арга хэмжээний тухай
3. 2015 оны төсвийн тодотгол батлах
4. 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны төсөв батлах
5. 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн тухай, 2016 оны төлөвлөгөөг батлуулах
6. Сум хөгжлийн сангийн зээлийн олголт, эргэн төлөлт, хяналтын үйл ажиллагааны тайлан тухай
7. Сумын ХАА-н салбарын хөгжлийн дэд хөтөлбөр /2016-2025 он/
8. 2015 онд ойгоос ашиглах түлш, хэрэглээний модны лимит, агнах барих ан амьтны тоо хэмжээ, байгалийн баялаг ашигласны төлбөрийн гүйцэтгэл, 2016 оны төлөвлөгөө батлуулах.
9. 90 жилийн ойн баярын хандивийн зарцуулалтын тайлангийн тухай.



МАЛЧИН СУМ:

УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг болон Нутгийн зөвлөлийн гишүүдийн санаачлагаар сумаа хөгжүүлж жишиг сум болгох зорилт тавьж иргэдээс санал сонсож бүх нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдийн санал сонслоо. Сум хөгжүүлэх ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу шат дараатай арга хэмжээнүүдийг зохион явууллаа.

бүх нийтийн хэлэлцүүлгээс гарсан санал:

Иргэд бүх нийтээрээ сумаа өөрчлөн шинэчилж, тохилог ая тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэх саналыг 100% зөвшөөрч, гар бие оролцон санаачлага гаргаж ажиллахаа илэрхийлж байна.

Гарсан шийдэл

Сум хөгжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж 3 удаа хуралдсан бөгөөд төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу сумын төвийн бүх өрхөөр орж иргэд сумаа хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж ажиллах, уг төслийг дэмжиж буй талаар гарын үсэг цуглууллаа.

Хэлэлцүүлгийг төрийн байгууллагууд, иргэд, сурагчдад тус тус 3 удаа зохион байгуулсан бөгөөд төрийн байгууллагын ажилчид 100%, иргэд 100%, сурагчид 100% тус тус дэмжлээ. Иргэдэд хийсэн хурлаар санал асуулга авахад иргэд сумаа өөрчлөх төслийг 100% дэмжсэн байна.

Нийт 420 иргэний санал сонсож гарын үсэг авсан. Авсан санал гарын үсгийг бүгдийг нь УИХ-ын гишүүн Н.Алтанхуягт хүргүүлж, иргэдээс гарсан саналын дагуу төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх шийдэлд хүрч төлөвлөлтийн багийг суманд ирүүлэх талаар дараагийн ажилд шилжлээ.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал